

31

“ДАРХАН ХҮНС” ХК-ийн хувьцаа

эзэмшигчдийн хурлын протокол

“ДАРХАН ХҮНС” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2015 оны 04-р сарын 24-ний өдрийн 14⁰⁰ цагт Дархан уул аймаг Дархан сум 5-р баг “Дархан Хүнс” ХК-ний байранд эхлэв.

ТУЗ-н гишүүд 1, Д.Бат-Эрдэнэ

2, С.Оюунчимэг

3, Б.Бат-Өлзий

4, Б.Батнасан

5, Т.Цэвэгмид

6, Т.Өлзийсайхан

7, ТУЗ-н нарийн бичиг Д.Мөнхцэцэг

8, АУДИТын хорооны гишүүд Д.Цэцэгбадрал

9, АУДИТын хорооны гишүүд Ц.Цэрэндолгор

Хурлын ирц: 475903 ширхэг хувьцаа эзэмшигч хуралд хүрэлцэн ирж компанийн нийт 617,718 ширхэг хувьцааны 77,042% ирсэн тул Компанийн тухай хууль, Монгол Улсын хуулийн 70,1 дүгээр зүйлийг үндэслэн “Дархан-Хүнс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцон хурлаа эхлэх үү 100%-н саналтайгаар батлав.

хурлын даргаар Т.Цэвэгмид, гишүүдээр А.Тунгалаг, Б.Бат-Өлзий нарыг 100%-н саналтайгаар батлав.

Тооллогын комиссын даргаар Д.Мөнхцэцэг, Гишүүдээр инженер Намуунгүрүү, мастер Цэрэндолгор нарыг 100%-н саналтайгаар батлав.

хурлаар хэлэлцэх асуудлыг Хурлын дарга Т.Цэвэгмид дэгийг танилцуулж 100%-н саналтайгаар батлуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компаний 2014 оны үйл ажиллагааны үр дүн, цаашдын зорилтын тухай. /Гүйцэтгэх захирал А.Тунгалаг хугацаа 20 минут/
2. Компанийн 2014 оны санхүүгийн үйл ажиллагааны тухай, тайлан тэнцлийн тухай /ерөнхий нягтлан бодогч Б.Төрмөнх хугацаа 20 минут/
3. Дархан-Хүнс ХК-ний 2014 оны санхүүгийн үйл ажиллагаанд өгөх үнэлэлт дүгнэлт /хянан шалгагч Д.Цэцэгбадрал хугацаа 20 минут/
4. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох /хурлын дарга хугацаа заахгүй/
5. Компаний 2015 оны бизнес төлөвлөгөө, түүний танилцуулга /Гүйцэтгэх захирал А.Тунгалаг хугацаа 20 минут/
6. Тооллогын комисс байгуулах
7. Компанийн хяналтын зөвлөлийг сонгох
8. Бусад асуудал

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны үр дүн, цаашдын зорилтын тухай Гүйцэтгэх захирал А.Тунгалаг 20 минут

Манайг Алдар овогтой Тунгалаг гэдэг Эдийн засгийн баклавар, бизнес удирдлагын магистр цолтой. 2008 оноос одоог хүртэл Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Дархан-Хүнс ХК-ний танилцуулга

- Байгуулагдсан огноо 1971 он
- Хувьцаат Компани болсон огноо 1993 он
- Ажиллагсадын тоо 117 үүнээс эрэгтэй 37, эмэгтэй 80
- Захиргаа удирдлагын 12
- Инженер техникийн 11
- Үндсэн үйлдвэрлэл 54
- Борлуулалтын 27
- Улирлын чанартай борлуулалт 4

Дархан-Хүнс ХК-ний үйлдвэрлэн худалдаалж буй бүтээгдэхүүний төрөл

- Талх
- Нарийн боов
- Сүү, сүүн бүтээгдэхүүн

Удирдлага Зохион байгуулалт 2014 онд ТУЗ-н дарга Б.Бат-Өлзий, Гүйцэтгэх захирал А.Тунгалаг, үйл ажиллагааны үндсэн 4 алба захиргаа удирлагын баг

Бидний эрхэм зорилго

Хүмүүсийн итгэж найдан амтархан иддэг эрүүл чанартай хүнсний бүтээгдэхүүнийг бид чин сэтгэлээсээ, технологийн өндөр түвшинд, дэлхийн стандартын дагуу үйлдвэрлэж хэрэглэгчдэд хүргэнэ.

Одоо амжилтаасаа танилцуулая

1, МҮХАУТанхим ТОП 150

2, Оны онцлох Хүрэл Меркуры

3, Хэвийн боов Дарханы дархлагдсан Брэнд бүтээгдэхүүн

4, Нийгмийн хариуцлагыг эрхэмлэгч байгууллага ДУАЗДарга тамгын газраас авсан

Хугацаа 14⁰⁰-14¹⁷ итгэлийн материалыг хавсаргав

2. Компанийн 2014 оны санхүүгийн үйл ажиллагааны тухай, тайлан тэнцлийн тухай /ерөнхий нягтлан бодогч Б.Төрмөнх хугацаа 20 минут/

Ерөнхий нягтлан бодогч Б.Төрмөнх итгэлийг хугацаа 14¹⁷-14³³ материалыг хавсаргав

3. Дархан-Хүнс ХК-ний 2014 оны санхүүгийн үйл ажиллагаанд өгөх үнэлэлт дүгнэлт Хянан шалгагч Д.Цэцэгбадрал /20 минут/

Дархан-хүнс ХК-ний борлуулалт өмнөх онтой харцуулахад бүх цех тасаг өссөн байна. Удирлагын зардал нэмэгдсэн гол шалтгаан нь бол Улаанбаатар хот руу борлуулалт орсонтой холбоотой. Удирлагын түлшний зардал нэмэгдсэн шалтгаан бол машин нэмэгдсэнтэй холбоотой. Өртөгийг зардал 6,7,8-р саруудад буурсан байна өвлийн улиралд өртөг нэмэгдэж байна. Борлуулалтын урамшуулал, буцаалт буурсан байна энэ бол сайн үзүүлэлт та бүхэн сайн компанид ажил явагдсантай холбоотой. Улаанбаатарын борлуулалтын буцаалт нэмэгдэж байна шүү. 2015 онд сайн анхаарч ажиллаарай. Цех болгоны үйлдвэрлэлт нэмэгдсэн мөртлөө ашгийн хэмжээ буурсан байна ганцхан сүүний цехийн үйлдвэрлэлтийн өртөг буурсан ашигтай ажилсан байна. 320,0 сая төгрөгийн зээл авч үндсэн хөрөнгөө нэмсэн. Үүнд УБ хотод 5 авто машин, 5тн тер авто машин 1 ширхэгийг худалдан авсан.

Анхаарах зүйлсүүд:

1. Хүний нөөц бодлого, үйлдвэрлэлийн техник технологийн асуудалд анхаарал хандуулж цехийн цехийн удирдлага, санхүүгийн багийг тогтвор сууршилтай ажиллуулах
2. Хотын борлуулалтын хэмжээг нэмэгдүүлж, барааны буцаалт нэгжид ноогдох борлуулалтын өртөг зардлыг багасгах арга хэмжээ авах
3. Хэрчсэн гурилын борлуулалтыг нэмэгдүүлж ашигтай ажиллах боломжийг бүрдүүлэх
4. Дараа тайлан гаргагчийн хуулийн хүчин төгөлдөр баримт авчирч тооцоо хийхийг шаардах хүчингүй баримттай тохиолдолд 10%-иар ХХОАТ хуулийн дагуу татварын өглөг үүсгэж баримт авчраагүй ажилтнаар төлүүлэх.
5. Бэлтгэн нийлүүлэгч болон бусхд байгууллагуудтай тооцоо нийлж, өглөг авлагыг сар тутам баталгаажуулж байх
6. Зээлийг яаралтай төлж дуусгах, хүүний зардлыг хэмнэх
7. Авлага, өглөг багасгаж хөрөнгийн чадвар дээшлүүлэх арга хэмжээ авах.

Дархан-Хүнс ХК-ний удирдлага, зохион байгуулалтад өгөх дүгнэлт **ХАНГАЛТТАЙ**

Дархан-Хүнс ХК-ний тайлан тэнцэлд өгөх дүгнэлт **ХАНГАЛТТАЙ** хугацаа 14³⁵-15⁰³ материалыг хавсаргав

4. Дархан-Хүнс ХК-ний 2015 оны компанийн бизнес төлөвлөгөөг Гүйцэтгэх захирал А.Тунгалаг танилцуулна. /хугацаа 20 минут/

хугацаа 15⁰⁵-15²⁰ материалыг хавсаргав

Хурлын дарга Т.Цэвэгмид: Тунгалаг захиралд баярлалаа Хугацаа 15¹⁰-15²⁰ Итгэл тавьсан та бүхэнд баярлалаа. Итгэл тавьсан хүмүүсээс асуух зүйл байна уу. Би Аудитын нягтлан нараас асуух зүйл байна

1. ТЭМ-н үнийн есөлт ямар байгаа юм бэ. Яагаад үнийг хэлэхгүй байна. Борлуулалт тоогоор өссөн мөртлөө өртөг яагаад буурсан бэ үүнийг надаа хэлж өгөөч вэ.

Төрмөнх нягтлан бодогч Доллор өссөнтэй холбоотой хуурай сүү 15% өссөн, гурил 20%, сахар 15%, масло 14% өссөн. ТЭМ-н үнэ нэмэгдсэн учраас өртөг өссөн харагдаж байгаа юм аа.

Цэцэгбадрал нягтан УБ хотод ажиллаж байгаа хүмүүс ямарч удирдлагагүй хяналтгүй ажиллаж байгаа тооцоог манай нэг нягтланд даатгаад өгсөн байсан. Сая 3-р сараас тустай нягтлантай болсон байна лээ. Одоо нэг хяналттай болж байна.

34
Бат-Өлзий захирал: Бид нар хамгийн ойр зах зээлрүү борлуулалт хийх ажил хийсэн юм үүнд бид нар том машин-1ш жижиг машин 5 ширхэгийг авсан та бүхэн гарсан зардал гэхийн оронд хөрөнгө оруулалт хийж байна гэж бодох хэрэгтэй. Өрсөлдөөн ширүүн байна. Үнэ өсгөх боломжгүй хямрал нөлөөлөлөөд байна. Зээлийн хувьд богино хугацаанд төлж дуусгана.

Бат-Эрдэнэ захирал: 2015 оны төлөвлөгөөнд засвар үйлчилгээг ерөөсөө оруулаагүй байна. Их болон урсгал засварыг яаж хийх тухай тусгайгүй байна. Бид нарт байр хэрэгтэй байна. Хэрчсэн гурил, буузны цех хийхэд үйлдэр байр хэрэгтэй үүний тулд лифт засварлах, байр сав бэлдэх хэрэгтэй үүнийг ерөөсөө тусгайгүй байна.

А.Тунгалаг гүйцэтгэх захирал: Бид нар зардлыг цех тасаг бүрээр гаргаж ажилладаг. Лиминт тогтоож явдаг. Бид нар цех тасгийг зогсоохгүй урсгал засвар хийгээд л явна.

1. Чихрийн үйлдвэрийн дээвэр засварлах хэсэгчлэн
2. Лифт засварлах
3. Чихрийн үйлдвэрийн 2 давхарт хэрчсэн гурил, цайны газрыг оруулах
4. Хэрчсэн гурилын цехийн байранд сүүний цехийн зайрмаг нүүж орно.
5. Дэлгүүрийн байрыг засварлах томруулах Бид нар ийм ажил төлөвлөөд байна.

Намуунгүрүү инженер: Би цахилгааны инженер мэргэжилтэй энэ үйлдвэрт ТҮАД-н ажилд ороод 1 сар болж байна. Орсон хугацаанаас эхлэн хөдөлмөр хамгаалалын зааварчлагааг байнга өгч байна. Зааварчилгааг авч байгаа хүн уншихгүй байна өгч байгаа хүн тайлбарлаж өгөхгүй байна. Цахилгаан сайн хийгдсэн байна. Зөвхөн газардуулга алга, үйлдвэрийн тоног төхөөрөмж сайн энэ тоног төхөөрөмжинд ямар алдаа байна гэхээр тосолгоо үйлчилгээг цаг хугацаанд нь хийгээгүй, зогсоож засахгүйгээр үргэжлүүлэн ажиллуулдаг юм байна. Тоног төхөөрөмжийг засварыг хийдэг хүмүүс дандаа өөрчлөгдсөн, тогтвор сууршилгүй байна. Авто машины эвдрэл их байна. Машины засварт их хэмжээний мөнгө орох магадлалтай байна. Хамаг ашигаа идэх вий гэдэг санаа зовж байна.

Т.Өлзийсайхан Маркатынгийн албаны дарга: УБ хотын борлуулалтын талаар асуух зүйл байна уу.

Би УБ хотын борокерын газраас ирсэн. Манай компани танай хувьцаа эзэмшигч хүний хувьд УБ хотын борлуулалт хэр ашигтай байгаа вэ.

Т.Өлзийсайхан: Бид нар бүх цэгээ судалаад 5 машин борлуулалтанд яваад эхэлсэн. Бүх дэлгүүрүүд манай бүтээгдэхүүнийг авч хэвшээд байгаа. Бид цаашид сайн ажиллах болно.

Хувьцаа эзэмшигч Бат-Өлзий : УБ хотын борлуулалтыг Дархан шиг болгон гэвэл 5-6 жил шаардлагатай. Урьд нь Эрдэнэт, Сэлэнгэ бас л 5 жил шаардагдсан. Тийм учраас бид нарт хугацаа хэрэгтэй байна.

Хувьцаа эзэмшигч Бат-Эрдэнэ захирал: цайны газрын тоног төхөөрөмж муу байна. Хоолондоо анхаараач ээ. 1,2-р хоол, салат өгөх ажиллагсаддаа витаминлаг хоол өгөөчэй.

Цэвэгмид: Бид УБ хотод өөрийн гэсэн хэрэглэгчтэй болтол маш их хугацаа хэрэгтэй, тийм учир та бүхэн шанралтгүй, бас зардал ч гарна. Эдийн засгийн шинжилгээг сайн гаргаачээ. Та бүхэн хүмүүстэй зөв талаас нь тайлбарлаж гаргаж өгч байгаач ээ. 2015 оны төлөвлөгөөг их

38
сайн гаргасан байна. Та бүхэн 2015 ондоо их сайн ажиллаж амжилттай ажиллаарай. Та бүхэнд ажлын амжилт хүсье.

Асуулт байхгүй бол дараагийн асуулт руу оръя. ТУЗ-н гишүүдийг танилцуулъя. Хугацаа 15²⁰-15⁴⁰

6. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох санал хэлэх хүн байна уу.

Хурлын дарга Т.Цэвэгмид

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат гишүүд

1, Д.Бат-Эрдэнэ

2, С.Оюунчимэг

3, Б.Бат-Өлзий

4, Б.Батнасан

5, Г.Эрдэнэсумъяа

6, Дамба нарыг 100%-н саналтайгаар батлав.

Хараат бус гишүүд

1, Т.Өлзийсайхан

2, Т.Цэвэгмид

3, Төмөрбаатар нарыг 100% саналтайгаар батлав

Хурлын дарга Т.Цэвэгмид Санал байна уу.

Хувьцаа эзэмшигч Б.Бат-Өлзий: өсдөлдөөн ширүүн байна гэсэн бид нар бол илүү чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж үйлдвэр маань өсөн дэвшиж байна бид нар томорхон тодорхой байна. Та бүхэнд баяр хүргэе. Та бүхэн амжилттай ажилласан байна. Бид нар сүүний үйлдвэрийг өргөжүүлэх, урсгал шугамтай болох, печенийн үйлдвэр оруулж ирэх гээд зөндөө төлөвлөгөө бид нарт байгаа. Бүгдээрээ энэ бүгдийн төлөө хамттай ажилая. Үйлдвэрлэл нэмэгдэх тусам ажиллагсадын цалин нэмэгдэх болно. эхний ээлжин зээлээ төлөөд дуусгачих дараа бусад асуудлаа ярилцая.

Д.Мөнхцэцэг: Тооллогын комиссын дүнг танилцуулав. ТУЗ-н зургаан гишүүн, хараат бус 3 гишүүн нарыг 100%-н саналтайгаар батлав.

Т.Цэвэгмид: Хуралдаа идэвхитэй оролцсон та бүхэнд баярлалаа. Ингээд хурлаа хаассаныг мэдэгдэж байна.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн

Д.Мөнхцэцэг